

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/79/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН СЭРГЭЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Т.Хүрэлбаатар

Утас: 70272248 Цахим хаяг: [khurelbaatart@audit.gov.mn](mailto:khurelbaatart@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	12
3. Аудитын тайлан .....	13
3.1 Ерөнхий зүйл .....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал.....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	18
4. Аудитын илрүүлэлт.....	18
4.1 Залруулсан алдаа.....	18
4.3 Албан шаардлага.....	19
4.4 Зөвлөмж .....	22

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
УИХ	Улсын Их Хурал
ДЭХГ	Дулаан эрчим хүчний газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/188

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Сөрөг дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөний улмаас Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний байгууллагаас цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар залруулагдаагүй 147,148.8 мянган төгрөгийн зөрчил илэрч тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан, санхүүгийн тайланд өргөн тархсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, санхүүгийн тайлангийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D 2022/2022-02-25 19020568

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>75,712,591.10</b>	<b>81,088,119.74</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>532,069.00</b>	<b>2,109,009.00</b>
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>532,069.00</b>	<b>2,109,009.00</b>
33510	Байгууллагаас авах авлага	532,069.00	2,109,009.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>75,180,522.10</b>	<b>78,979,110.74</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>25,200,000.00</b>	<b>28,868,000.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	25,200,000.00	28,868,000.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>49,980,522.10</b>	<b>50,111,110.74</b>
35410	Бичиг хэргийн материал	1,116,300.00	805,800.00
35420	Аж ахуйн материал	40,915,766.10	41,784,266.10
35430	Сэлбэг хэрэгсэл	1,440,000.00	1,440,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,016,911.55	0.19
35450	Барилгын засварын материал	361,600.00	1,082,100.00
35460	Хүнсний материал	6,000.00	0
35470	Бусад хангамжийн материал	5,123,944.45	4,998,944.45
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>920,593,363.53</b>	<b>994,123,288.09</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>920,593,363.53</b>	<b>994,123,288.09</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>909,110,863.53</b>	<b>982,706,788.09</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	965,947,981.78	959,261,893.78
39202	Хуримтлагдсан элэгдэл	-356,311,417.57	-409,885,075.45
39203	Авто-тээврийн хэрэгсэл	163,659,400.00	220,026,066.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-135,409,400.38	-145,126,067.08
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	84,244,650.00	76,253,330.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-56,597,186.61	-55,564,186.15
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,974,200.00	51,987,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-17,001,276.17	-19,794,472.95
39214	Бусад үндсэн хөрөнгө	414,810,988.15	504,839,407.15
39215	Хуримтлагдсан элэгдэл	-184,207,075.67	-199,291,107.21
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>11,482,500.00</b>	<b>11,416,500.00</b>
39301	Програм хангамж	2,345,000.00	2,345,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,262,500.00	-2,328,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	11,400,000.00	11,400,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>996,305,954.63</b>	<b>1,075,211,407.83</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>996,305,954.63</b>	<b>1,075,211,407.83</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>996,305,954.63</b>	<b>1,075,211,407.83</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	892,403,902.95	892,403,902.95
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>70,191,342.39</b>	<b>149,096,795.59</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	114,440,423.78	70,191,342.39
51220	Тайлант үеийн үр дүн	-44,249,081.39	78,905,453.20
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	33,710,709.29	33,710,709.29
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>996,305,954.63</b>	<b>1,075,211,407.83</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>678,404,494.80</b>	<b>676,512,491.65</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>96,451,182.95</b>	<b>228,779,965.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>96,451,182.95</b>	<b>228,779,965.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>31,589,181.95</b>	<b>0</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	31,589,181.95	0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	64,862,001.00	228,779,965.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>581,953,311.85</b>	<b>447,732,526.65</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>52,213,911.85</b>	<b>76,135,126.65</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	8,306,410.00	15,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	31,864,601.85	37,473,220.65
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,042,900.00	23,161,906.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>529,739,400.00</b>	<b>371,597,400.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	529,739,400.00	371,597,400.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>719,657,976.19</b>	<b>596,607,038.45</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>719,657,976.19</b>	<b>596,607,038.45</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>650,177,478.49</b>	<b>560,491,974.68</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>250,789,900.96</b>	<b>237,480,297.89</b>
210101	Үндсэн цалин	166,829,194.21	167,866,185.24
210102	Нэмэгдэл	42,641,906.75	30,709,295.30
210105	Гэрээт ажлын хөлс	41,318,800.00	38,904,817.35
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>31,039,481.41</b>	<b>31,717,277.17</b>
210201	Тэтгэврийн даатгал	21,882,313.61	21,434,496.17
210202	Тэтгэмжийн даатгал	2,341,228.94	2,236,843.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,846,339.11	1,789,474.45
210204	Ажилгүйдлийн даатгал	457,523.62	441,886.90
210205	Эрүүл мэндийн даатгал	4,512,076.13	5,814,576.64
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>29,489,249.55</b>	<b>28,077,666.95</b>
210301	Гэрэл, цахилгаан	25,690,014.00	27,920,366.95
210302	Тулш, халаалт	3,799,235.55	157,300.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>32,442,468.35</b>	<b>29,681,017.99</b>
210401	Бичиг хэрэг	4,887,850.00	3,082,120.00
210402	Тээвэр, шатахуун	13,938,088.35	23,636,404.36
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,999,930.00	1,471,623.63
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0	1,218,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,616,600.00	272,070.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>6,569,709.20</b>	<b>472,010.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,569,709.20	472,010.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,573,664.00</b>	<b>3,233,816.00</b>
210604	Урсгал засвар	3,573,664.00	3,233,816.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,688,000.00</b>	<b>5,980,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	5,688,000.00	5,980,000.00

Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>25,958,999.00</b>	<b>19,764,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,261,499.00	19,632,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	297,500.00	0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	132,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>264,626,006.02</b>	<b>204,085,888.68</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	75,588,139.75	43,995,448.24
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0	140,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	189,037,866.27	159,950,040.44
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>69,480,497.70</b>	<b>36,115,063.77</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>38,892,700.00</b>	<b>0</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	37,892,700.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	0
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>30,587,797.70</b>	<b>36,115,063.77</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,587,797.70	36,115,063.77
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>-41,253,481.39</b>	<b>79,905,453.20</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,995,600.00</b>	<b>1,000,000.00</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	664,600.00	1,000,000.00
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	2,331,000.00	0
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-44,249,081.39</b>	<b>78,905,453.20</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	892,403,902.95	33,710,709.29	114,440,423.78	1,040,555,036.02
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	892,403,902.95	33,710,709.29	114,440,423.78	1,040,555,036.02
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-44,249,081.39	-44,249,081.39
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	892,403,902.95	33,710,709.29	70,191,342.39	996,305,954.63
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	892,403,902.95	33,710,709.29	70,191,342.39	996,305,954.63
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	892,403,902.95	33,710,709.29	70,191,342.39	996,305,954.63
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	78,905,453.20	78,905,453.20
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	892,403,902.95	33,710,709.29	149,096,795.59	1,075,211,407.83

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>613,542,493.80</b>	<b>447,732,526.65</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>613,542,493.80</b>	<b>447,732,526.65</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>83,803,093.80</b>	<b>76,135,126.65</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	8,306,410.00	15,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	63,453,783.80	37,473,220.65
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,042,900.00	23,161,906.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>529,739,400.00</b>	<b>371,597,400.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	529,739,400.00	371,597,400.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>477,555,835.25</b>	<b>442,032,526.65</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>477,555,835.25</b>	<b>442,032,526.65</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>408,075,337.55</b>	<b>405,917,462.88</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>249,111,706.75</b>	<b>237,105,368.71</b>
210101	Үндсэн цалин	165,151,000.00	167,491,256.06
210102	Нэмэгдэл	42,641,906.75	30,709,295.30
210105	Гэрээт ажлын хөлс	41,318,800.00	38,904,817.35
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>31,993,451.95</b>	<b>30,918,698.75</b>
210201	Тэтгэврийн даатгал	22,836,284.15	20,635,917.75
210202	Тэтгэмжийн даатгал	2,341,228.94	2,236,843.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,846,339.11	1,789,474.45
210204	Ажилгүйдлийн даатгал	457,523.62	441,886.90
210205	Эрүүл мэндийн даатгал	4,512,076.13	5,814,576.64
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>29,467,009.00</b>	<b>29,419,406.75</b>
210301	Гэрэл, цахилгаан	25,141,909.00	27,070,106.75
210302	Тулш, халаалт	4,325,100.00	2,267,300.00
210303	Цэвэр, бохир ус	0	82,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>19,489,280.00</b>	<b>14,802,379.63</b>
210401	Бичиг хэрэг	4,096,150.00	2,552,500.00
210402	Тээвэр, шатахуун	13,316,200.00	8,541,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,076,930.00	1,708,929.63
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0	1,999,100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>998,310.00</b>	<b>996,800.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	998,310.00	996,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,910,787.00</b>	<b>3,000,000.00</b>
210604	Урсгал засвар	5,910,787.00	3,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,688,000.00</b>	<b>6,412,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	5,688,000.00	6,412,000.00

Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>37,418,979.00</b>	<b>28,935,368.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,541,479.00	27,826,271.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	350,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	297,500.00	479,097.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	180,000.00	180,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	100,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>27,997,813.85</b>	<b>54,327,441.04</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,997,813.85	54,171,441.04
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0	156,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>69,480,497.70</b>	<b>36,115,063.77</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>38,892,700.00</b>	<b>0</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	37,892,700.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	0
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>30,587,797.70</b>	<b>36,115,063.77</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,587,797.70	36,115,063.77
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>135,986,658.55</b>	<b>5,700,000.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>135,986,658.55</b>	<b>5,700,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>135,986,658.55</b>	<b>5,700,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>135,986,658.55</b>	<b>5,700,000.00</b>
220001	Барилга байгууламж	16,900,000.00	0
222001	Тоног төхөөрөмж	23,831,580.00	0
223001	Бусад хөрөнгө	21,671,950.00	0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	73,583,128.55	5,700,000.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-135,986,658.55</b>	<b>-5,700,000.00</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>371,597,400.00</b>	<b>355,297,200.84</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>371,597,400.00</b>	<b>355,297,200.84</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>371,597,400.00</b>	<b>355,297,200.84</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>249,142,000.00</b>	<b>237,105,368.71</b>
210101	Үндсэн цалин	164,370,300.00	167,491,256.06
210102	Нэмэгдэл	43,452,900.00	30,709,295.30
210105	Гэрээт ажлын хөлс	41,318,800.00	38,904,817.35
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>33,634,100.00</b>	<b>30,918,698.75</b>
210201	Тэтгэврийн даатгал	23,668,500.00	20,635,917.75
210202	Тэтгэмжийн даатгал	2,491,400.00	2,236,843.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,993,200.00	1,789,474.45
210204	Ажилгүйдлийн даатгал	498,300.00	441,886.90
210205	Эрүүл мэндийн даатгал	4,982,700.00	5,814,576.64
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>33,120,000.00</b>	<b>32,619,406.75</b>
210301	Гэрэл, цахилгаан	24,308,000.00	30,270,106.75
210302	Түлш, халаалт	7,612,000.00	2,267,300.00
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.00	82,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>13,347,100.00</b>	<b>13,345,129.63</b>
210401	Бичиг хэрэг	2,552,500.00	2,552,500.00
210402	Тээвэр, шатахуун	7,084,600.00	7,084,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,710,000.00	1,708,929.63
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	1,999,100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,000,000.00</b>	<b>996,800.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	996,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,000,000.00</b>	<b>3,000,000.00</b>
210604	Урсгал засвар	3,000,000.00	3,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,202,400.00</b>	<b>4,470,400.00</b>
210702	Дотоод албан томилолт	5,202,400.00	4,470,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,130,000.00</b>	<b>6,109,097.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,000,000.00	5,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	350,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	479,097.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	180,000.00	180,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	100,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>27,021,800.00</b>	<b>26,732,300.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,021,800.00	26,732,300.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>371,597,400.00</b>	<b>355,297,200.84</b>
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>349,575,600.00</b>	<b>355,297,200.84</b>
320001	Орон нутгийн төсвөөс	349,575,600.00	355,297,200.84
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>22,021,800.00</b>	<b>0</b>
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	22,021,800.00	0

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>56,320,262.04</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>56,320,262.04</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	56,320,262.04
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,457,250.00
210402	Тээвэр, шатахуун	1,457,250.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,941,600.00
210702	Дотоод албан томилолт	1,941,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	22,826,271.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,826,271.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	30,095,141.04
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,939,141.04
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	156,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>56,320,262.04</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>56,320,262.04</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	15,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,658,356.04
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	23,161,906.00

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Хүрэлбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03/12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газар нь Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэж иргэдтэй ойр харилцах харилцааг бий болгох зорилго бүхий байгууллага юм.

Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар дотоод хяналт шалгалтын ажлын хэсэг 3 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулан батлагдсан төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. Тус байгууллагад дотоод аудитын нэгж байхгүй байна.

Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын 676,512.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 6,765.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 5,073.8 мянган төгрөгөөр тогтоосон.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Энэхүү Санхүүгийн тайлангаар Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг толилуулж байна. Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.4 дэх заалтыг үндэслэн Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС) болон Монгол Улсын холбогдох хууль, журам, заавар, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккрузал сууриар бэлтгэн тайлагнасан байна.

#### **Орлого:**

Тус байгууллага 2021 онд орон нутгийн төсвөөс 371,597.4 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд 76,135.1 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 228,779.9 мянган төгрөг нийт 676,512.4 мянган төгрөг, өмнөх оноос 1,892.0 мянган төгрөгөөр буюу 0.3 хувиар буурсан байна. Энэ нь санхүүжилт буурсантай холбоотой байна.

#### **Зардал:**

Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангаар 596,607.0 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар 447,732.5 мянган төгрөг, төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 355,297.2 мянган төгрөг зарцуулсан байна.

**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:**

Тус байгууллага төрийн сангийн 100141751001 тоот дансанд 2021 онд 447,732.5 мянган төгрөгийн орлогын, 447,732.5 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг байна. Мөн нэмэлт санхүүжилтийн 100141751408 тоот дансанд 76,135.1 мянган төгрөгийн орлого төвлөрч 76,135.1 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж үлдэгдэл 0 төгрөг байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мян.төгрөг/ Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	532.0	2,109.0	1,577.0
Урьдчилгаа			
Бараа материал	75,180.5	78,979.1	3,798.6
Үндсэн хөрөнгө	920,593.3	1,031,085.6	110,492.3
Нийт хөрөнгө	996,305.9	1,112,173.7	115,867.8
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	996,305.9	1,112,173.7	115,867.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	996,305.9	1,112,173.7	115,867.8

Авлагын дансны үлдэгдэл 2,109.0 мянган төгрөг болж 1,577.0 мянган төгрөгөөр өссөн нь шатахууны авлага үүссэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 78,979.1 мянган төгрөг болж 3,798.6 мянган төгрөгөөр өссөн нь бараа материалын худалдан авалтаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,031,085.6 мянган төгрөг болж 110,492.3 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгөтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 5,700.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй шилжиж ирсэн 228,779.9 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, 80,749.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө данснаас хасаж акталсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,112,173.7 мянган төгрөг болж 115,867.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

**3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 515,491.5 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний нийт зарлагыг 495,259.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 143,894.1 мянган төгрөгөөр бууруулж орон нутгийн төсвөөс 371,597.4 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна. Энэ нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, эд хогшил урсгал засварын зардал, томилолт зочны зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг бууруулсантай холбоотой байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 371,597.4 мянган төгрөгийн төсвийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 371,597.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 355,297.2 мянган төгрөгийг зарцуулж 16,300.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл мянган төгрөг буюу 95.6 хувьтай байгаа нь орон тоо дутуу ажилласнаас цалин, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал зарцуулаагүй үлдэгдэлтэй, цар тахалтай холбоотой танхимын сургалт семинар зохион байгуулаагүйн улмаас томилолт, зочны зардлын гүйцэтгэл 87.8 хувьтай, Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 94.2 хувьтай зарцуулагдсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Оны эхний үлдэгдэл 20,951.8 мянган төгрөг байсан. Аймгийн Засаг даргын Тамгын газраас ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд 6,860.0 мянган төгрөг, сүүдрэвчийн үнэ 2,500.0 мянган төгрөг, буганд өгөх өвсний үнэ 500.0 мянган төгрөг, Төв Чандмань ДЭХГ-аас Засгийн газраас төлсөн усны үнэ 3,784.7 мянган төгрөг, худгийн ажилтны усны орлого 615.3 мянган төгрөг, аймгийн Статистикийн хэлтсээс хагас жилийн мал тооллого, сургалтын зардалд 774.2 мянган төгрөг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас хамтарсан багийн санхүүжилтэд 300.0 мянган төгрөг, Онцгой байдлын газраас постны томилолтод 2,196.0 мянган төгрөг, тендерийн хураамж 175.0 мянган төгрөг, өвсний мөнгө 21,478.0 мянган төгрөг, ковид 19 цар тахалтай холбоотой иргэн, аж ахуйн нэгжээс нийгмийн хариуцлагын гэрээний дагуу 10,000.0 мянган төгрөг, хандив 5,500.0 мянган төгрөг, УИХ-ын гишүүн Ж.Батжаргал 500.0 мянган төгрөг, нийт 76,135.0 мянган төгрөгийн орлого, болон санхүүжилт бүрдүүлжээ.

Үүнээс тээвэр шатахууны зардалд 1,457.2 мянган төгрөг, дотоод томилолтын зардалд 1,941.6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр

хураамжид 22,826.3 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 29,939.1 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 156.0 мянган төгрөг, нийт 56,320.2 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 19,814.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын даргаар С.Ганчимэг 2021 оны 2 дугаар сар хүртэл, Б.Мөнхцэцэг 2021 оны 2 дугаар сараас 11 дүгээр сар дуустал, Л.Дашлхагва 2021 оны 12 дугаар сараас эхлэн ажиллаж байна.

Тайлант онд иргэн, аж ахуйн нэгжээс ковид-19 цар тахалтай холбоотой хандив 5,500.0 мянган төгрөг, нийгмийн хариуцлагын гэрээгээр 10,000.0 мянган төгрөг, нийт 15,500.0 мянган төгрөгийг авч зарцуулсан байна.

Нийт 2,893.7 мянган төгрөгийн цалинг Төрийн албаны цалингийн нэгдсэн системээр бус арилжааны банк, ажилтны хувийн дансаар олгосон байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газар нь нийт 33,223.3 мянган төгрөгийн худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй байна.

Худгийн усны орлого 2,998.5 мянган төгрөг, Засгийн газраас чөлөөлсөн усны буцаан олголт 1,401.5 мянган төгрөг нийт 4,400.0 мянган төгрөгөөс 592.2 мянган төгрөгийг усны төлбөр төлсөн иргэдэд эргүүлэн олгож үлдсэн 3,807.7 мянган төгрөгийг иргэдэд эргүүлэн олгоогүй зарцуулсан байна.

Бараа материалын тайланг сар бүр нэр төрлөөр гаргадаггүй, бараа материалыг бөөн дүнгээр зарлагддаг, шатахууны тооцоог боддоггүй, эд хөрөнгийн тооллогыг хийсэн боловч тооцоог бодоогүй, өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт гараагүй байна.

Аюулгүйн нөөцийн өвс тэжээлийн тооцоог хийж үзэхэд нийт 22,308.0 төгрөгийн үнэ бүхий 1000 шуудай тэжээл, 234 боодол өвсийг орлогод авалгүй зарцуулсан, Засаг дарга болон багийн дарга, нягтлан бодогч нярав нар нь өвс тэжээлийн мөнгийг харилцах дансанд тушаалгүй хувийн данс болон бэлнээр тэжээл худалдан авсан, өвөлжилт хүндэрсэн үед малчин болон мал бүхий иргэдэд хямд үнээр олгох өвс, тэжээлийг үндэслэлгүй үнэ нэмж зарсан, 600 шуудай тэжээлийг өмнөх Засаг дарга төлбөр төлөлгүй авсан байна.

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглагдаж байгаа 58,641.9 мянган төгрөгийн балансын үнэтэй үндсэн хөрөнгийн ашиглах жилийн сунгаагүй, өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт гараагүй байхад акталж данснаас хассан байна.

Оны эцэст зарцуулаагүй шатахууны үлдэгдэл болох 1,576.9 мянган төгрөгийг төвлөрүүлэлгүй авлага үүсгэж нөөцөлсөн.

Байгууллагын цалингийн сангаас орон тоо нь батлагдаагүй худгийн түгээгчийг 3,271.6 мянган төгрөгөөр цалинжуулсан.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цэсэнд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 146 мэдээллээс хугацаандаа мэдээлсэн 130 мэдээлэл, хугацаа хоцроосон 8 мэдээлэл, мэдээлээгүй 8 мэдээлэл байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллага нь санхүүгийн тайлангийн аудитад шаардлагатай баримт, материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Тус байгууллага 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 зөвлөмж, 1 албан шаардлагын хэрэгжилтийг 2021 оны 6 дугаар сарын 15-ний өдрийн 03/129 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Нэмэлт дансан дахь орлогын талаар дараагийн аудитаар авч үзнэ.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 220,226.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 73,077.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,576.9 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 145,571.9 мянган төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага, 1 зөрчилд зөвлөмж өгөв.

### **4.1 Залруулсан алдаа**

Нийт 7 нэр төрлийн 8 ширхэг үндсэн хөрөнгөнд 36,962.3 мянган төгрөгийн элэгдэл бодоогүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Төсвийн зарцуулаагүй үлдэгдэл болох 36,115.0 мянган төгрөгийг төвлөрүүлснийг буруу кодоор тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

#### 4.2 Төлбөрийн акт

Оны эцэст зарцуулаагүй шатахууны үлдэгдэл болох 1,576.9 мянган төгрөгийг төвлөрүүлэлгүй авлага үүсгэж нөөцөлсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 45 дугаар зүйлийн 45.2-т “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, 45.2.1-д “нэгжид ногдох норм, нормативаар тооцон төсвийг нь баталсан ба гүйцэтгэл нь анх тооцсон нэгжийн тоо хэмжээнээс бага бол”, санхүүгийн тайлангийн аудитын “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэсэн заалтын дагуу төлбөрийн акт тогтоов.

#### 4.3 Албан шаардлага

Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг /дансны хуулгын дүнг/ Татварын Е баримт, Е постын дүнтэй тулгалт хийхэд Е баримтын дүн шилжүүлсэн мөнгөн дүнгээс 33,223.3 мянган төгрөгөөр дутуу, 10,313.6 мянган төгрөгөөр илүү байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй”, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар”-ын 6.5-д Төлбөрийн баримт “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр

хувь үйлдэнэ”, санхүүгийн тайлангийн аудитын “Иж бүрэн байх”, “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.1-д “Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

Худгийн усны орлого 2,998.5 мянган төгрөг, Засгийн газраас чөлөөлсөн усны буцаан олголт 1,401.5 мянган төгрөг нийт 4,400.0 мянган төгрөгөөс 592.2 мянган төгрөгийг усны төлбөр төлсөн иргэдэд эргүүлэн олгож үлдсэн 3,807.7 мянган төгрөгийг иргэдэд эргүүлэн олголгүй зарцуулж иргэдийг хохироосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.4-т “Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн аудитын “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

Бараа материалын тайланг сар бүр нэр төрлөөр гаргадаггүй, бараа материалыг бөөн дүнгээр зарлагддаг, шатахууны тооцоог боддоггүй байна. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 9-д “Бараа материалын тайланг агуулахын нярав, эд хариуцагч нь аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан хугацаанд агуулахын бүртгэлд үндэслэн материалын нэр төрөл тус бүрийн тоо хэмжээгээр нэгтгэн гаргана. Бараа материалын тайланг нярав, эд хариуцагч нар дээр хөтлөгдөж буй агуулахын бүртгэлтэй тулган шалгаж хүлээж авна” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн аудитын “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.1-д “Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

Эд хөрөнгийн тооллогыг хийсэн боловч тооцоог бодоогүй, өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт гараагүй, шатахууны тооцоо бодоогүй, спидометрийн заалт дутуу бичдэг, шатахууныг бөөн дүнгээр зарлагддаг байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ” 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн аудитын “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.2-т “Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

Байгууллагын цалингийн сангаас орон тоо нь батлагдаагүй худгийн түгээгчийг 3,271.6 мянган төгрөгөөр цалинжуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн аудитын “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглагдаж байгаа 58,641.9 мянган төгрөгийн балансын үнэтэй үндсэн хөрөнгийн ашиглах жилийн сунгаагүй, өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт гараагүй байхад акталж данснаас хассан байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 7 дахь хэсэг 7.2-т “Эрх бүхий байгууллагын шийдвэрээр акталж, данснаас хасахаар шийдвэрлэж, зөвшөөрөл авсан боловч ашиглалтын шаардлага хангаж байгаа, дахин ашиглах боломжтой хөрөнгийн үнийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай зөвшилцөн тогтоож, дахин данс бүртгэлд тусгана” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн аудитын “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Оршин байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

Аюулгүйн нөөцийн өвс тэжээлийн тооцоог хийж үзэхэд нийт 22,308.0 мянган төгрөгийн үнэ бүхий 1000 шуудай тэжээл, 234 боодол өвсийг орлогод авалгүй зарцуулсан, Засаг дарга болон болон багийн дарга, нягтлан бодогч нярав нар нь өвс тэжээлийн мөнгийг харилцах дансанд тушаалгүй хувийн данс болон бэлнээр тэжээл худалдан авсан, өвөлжилт хүндэрсэн үед малчин болон мал бүхий иргэдэд хямд үнээр олгох өвс, тэжээлийг үндэслэлгүй үнэ нэмж зарсан, 600 шуудай тэжээлийг өмнөх Засаг дарга төлбөр төлөлгүй авсан зөрчлийг хуулийн байгууллагад шилжүүлж шалгуулахаар шийдвэрлэв.

Шийдвэрлэсэн нь: Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

#### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### ***Нийцлийн аудиттай холбоотой асуудал***

###### ***Илрүүлэлт:***

Шилэн дансны цэсэнд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 146 мэдээллээс хугацаандаа мэдээлсэн 130 мэдээлэл, хугацаа хоцроосон 8 мэдээлэл, мэдээлээгүй 8 мэдээлэл байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### ***Өгсөн зөвлөмж:***

- Шилэн дансанд байршуулбал зохих мэдээллийг үнэн зөв, бүрэн гүйцэд, тухай бүр мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа. зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс									
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хуулийн байгууллагад шилжүүлэх	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Сэргэлэн ЗДТГ	11	211,438.0	2	73,077.4	1	1,576.9	7	145,571.9	1	0	0	0